



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/288

Ховд

「 Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай」


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн тавдугаар хуралдааны 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Хөшөөт хөгжил сангийн 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.2 дахь заалт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардал 413,000,000 төгрөгийн зарцуулах, тайлагнах эрхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Б.Сандагсүрэн)-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээг хууль журмын хүрээнд зохион байгуулахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Б.Сандагсүрэн)-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтыг хянан санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д хариуцуулсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1461